



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 10 өдөр

Дугаар 1564

Улаанбаатар хот

Г Коронавируст халдварт (КОВИД-19)-ын
эсрэг вакцины нэмэлт тунгаар
вакцинжуулах тухай


Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.24, 35 дугаар зүйлийн 35.6, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 14 дүгээр зүйлийн 14.1, Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын эсрэг дархлааны түвшинг нэмэгдүүлэх зорилгоор 18-аас дээш насны иргэдийг сайн дурын үндсэн дээр коронавируст халдварт (КОВИД-19)-ын эсрэг вакцины нэмэлт нэг тунгаар вакцинжуулах ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн зохион байгуулсугай.
2. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын эсрэг вакцины хоёр тунд бүрэн хамрагдсан, хоёр дахь тунг тарьснаас хойш гурван сар өнгөрсөн байх шалгуурт нийцэх иргэнийг коронавируст халдварт (КОВИД-19)-ын эсрэг Пфайзер-БиоНТех үйлдвэрийн "Комирнэти", Синофарм/BBIBP үйлдвэрийн "CorV" вакцинаас сонголт хийлгэн, дархлаа сэргээх тунгаар вакцинжуулсугай.
3. Дархлаа сэргээх нэмэлт нэг тунгаар вакцинжуулахад шаардагдах Пфайзер-БиоНТех үйлдвэрийн "Комирнэти", Синофарм/BBIBP үйлдвэрийн "CorV" вакцин, тариур, аюулгүй хайрцгийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын хэрэгцээ, захиалгад үндэслэн хуваарилах, түгээх үйл ажиллагааг зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/-д үүрэг болгосугай.
4. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын эсрэг Пфайзер-БиоНТех үйлдвэрийн "Комирнэти" вакцины зааврыг хавсралтаар баталсугай.
5. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын эсрэг вакцины нэмэлт тунгаар вакцинжуулах арга хэмжээг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн тусlamжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Л.Энхсайхан/, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/-д, вакцинжуулалтын үйл ажиллагааг зохион байгуулж, цэгийн тоог нэмэгдүүлэх, дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг бүртгэх, мэдээлэх, тандах журмын

хэрэгжилтийг чанд мөрдөж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус даалгасугай.

6. Дархлаажуулалтын цахим бүртгэлийн програмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын Мэдээлэл, технологийн хэлтэс /Б.Цэрэн-Очир/-т даалгасугай.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээний газар /С.Төгсдэлгэр/-т үүрэг болгосугай.



Эрүүл мэндийн сайдын 2021 оны 09 дугаар сарын 10...-ны өдрийн 47504 дугаар тушаалын хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЭСРЭГ ПФАЙЗЕР-БИОНТЕХ ҮЙЛДВЭРИЙН “КОМИРНЭТИ” ВАКЦИНЫГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР (COMIRNATY)

“Комирнэти” вакциныг mRNA платформын аргаар үйлдвэрлэсэн бөгөөд коронавируст халдварт (КОВИД-19)-аас сэргийлэх зорилгоор хэрэглэнэ.

Найрлага:

Тус вакцин SARS-CoV-2 вирусийн эсрэгтөрөгчийг агуулсан ба найрлагад нэмэлт нөөшлүүр бодис ороогүй. Вакцинд нэмэлтээр калийн хлорид, калийн дигидрофосфат, натрийн хлорид, динатрифосфат дигидрат, 4-гидроксибутил аценедил, гексан-6, 2-гексилдекант, АЛК-0315, полиэтиленгликол, Н-дитетрадекилацетамид, 1,2 дистеороил глицеро-3 фосфохололин, холестерол, сахароз орсон.

Вакциныг уусгагч шингэн болох 0.9%-ийн натрийн хлорид (рН: 6.9-7.9) дагалдана.

Савлагагаа:

Нэг хүн тун нь 0.3 мл, флаконд 6 хүн тунгаар савлагдсан. Вакцин нь бага зэрэг цайвар өнгөтэй, гель хэлбэрийн хөлдөөсөн суспенз. Уусгагч шингэн 0.9%-ийн натрийн хлоридын уусмал дагалдаж ирнэ.

Тун ба тарих арга:

Вакциныг булчинд тарина. 12 ба түүнээс дээш насны хүмүүст 0.3 мл-ээр булчинд тарьж хэрэглэнэ. Эхний тунгаас 21 хоногийн дараа хоёр дахь тунг тарина. Вакциныг дагалдаж ирсэн уусгагч шингэн болох 0.9%-ийн натрийн хлоридын уусмалаас 1.8 мл-ийг найруулах тариураар соруулан авч вакциныг найруулна. Найруулсан вакциныг 6 цагийн дотор хэрэглэх бөгөөд үлдэгдлийг устгана.

Эсрэг заалт:

- Харшлын өгүүлэлмжтэй;
- Өмнө нь анафилаксийн урвал өгч байсан;
- Цочмог халдварт өвчнөөр өвчилсөн;
- Сүүлийн нэг жилийн хугацаанд таталт өгсөн;
- Мэдрэлийн үрэвслийн хам шинжийн үед;
- Өмнө нь ямар нэг вакцин хийлгээд хүнд хэлбэрийн урвал илэрч байсан.

Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл:

- Халуурах, толгой өвдөх, чичрэх, ядрах, булчин өвдөх, үеэр өвдөх, тариулсан газарт улайх, хөндүүрлэх, хавдах зэрэг шинж тэмдэг 10 хүн тутмын 1-ээс олон хүнд; тарьсан газар улайх, дотор муухайрах зэрэг шинж тэмдэг 10 хүн тутмын 1-д илэрч болно. Түгээмэл тохиолдох шинж тэмдэг илэрснээс хойш 2-3 өдрийн дараа хэвийн байдалд ордог.

- Түгээмэл бус тохиолдох шинж тэмдэг (100 хүн тутмаас 1 хүнд): Лимфаденопати, тайван бус болох, үе мөч өвдөх, нойргүйдэх, вакцин тарьсан газар загатнах.
- Ховор тохиолдолд энцефаломиелит, анафилаксийн шок, харшлын урвал, татах, мэдрэлийн тогтолцооны үрэвсэл, захын мэдрэлийн үрэвсэл, тромбоцитопени, түр зуурын нэг талын нүүрний булчингийн саа зэрэг хүнд урвал илэрч болно. Хэрэв дээрх шинж тэмдэг илэрвэл эмчилгээг яаралтай эхэлнэ.

Хөхүүл эх:

Хөхүүл эхчүүдэд вакциныг хийж болно.

Анхааруулга:

- Дархлааны дутмагшилтэй
- Дааврын болон дархлаа дарангуйлах, дархлаа сэргээх эмчилгээ хийлгэж байгаа
- Цус гоожих хам шинжтэй
- Цус бүлэгнэлтийн эсрэг эмчилгээ хийлгэж байгаа
- Архаг өвчний сэдрэлтийн үе
- Бусад вакцинтай нэг өдөр хийж болохгүй ба бусад вакцинтай нэг сарын зайдай хийнэ.
- Иммуноглобулин, цус, ийлдэс хийлгэсэн бол 3 сарын дараа вакцин хийлгэнэ.

Хадгалах тээвэрлэх:

- Вакциныг -60 -80 хэмд ультра гүн хөлдөөгчид хөлдөөж хадгална. Вакциныг хийхээсээ өмнө -60 -80 хэмийн ультра гүн хөлдөөгчөөс цаасан хайрцагтай нь гарган, +2+8 хэмийн хөргөгчинд 3 цаг хадгалан гэсгээнэ. Гэсгээсэн вакциныг +2+8 хэмд 30 өдөр хадгалж, хэрэглэнэ. Вакциныг дагалдаж ирсэн уусгагч шингэнээр найруулна. Найруулсан вакциныг +2+8 хэмд 6 цаг хадгалж хэрэглэх ба нарны шууд тусгалд тавьж болохгүй.
- Уусгагч шингэнийг +2+8 хэмд хадгална. Уусгагч шингэнийг хөлдөөж болохгүй.
- Найруулсан вакциныг хөлдөөж болохгүй.
- Гэсгээсэн вакциныг дахин хөлдөөж болохгүй.

Үйлдвэрлэгч: ХБНГУ, Pfizer-BioNTech компани. info@biontech.de

-оОо-